

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022 /23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2022 он

Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 7035 9826
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 7035 8505
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитор: Б.Байгал
Утас: 99359854
Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗГНХ	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ТЗ	Төрийн захиргаа
ТҮ	Төрийн үйлчилгээ
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвараа түр алдалтын тэтгэмж



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 17

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ОТГОНБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,698,268.49</u>	<u>60,289,064.10</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	843,305.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	843,305.50
3121	Төгрөг	00.00	843,305.50
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	843,305.50
35	БАРАА МАТЕРИАЛ	31,698,268.49	59,445,758.60
351	Түүхий эд материал	13,952,450.75	15,007,012.10
35110	Тусгай зориулалттай материал	13,952,450.75	15,007,012.10
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,129,225.00	1,002,725.00
354	Хангамжийн материал	16,616,592.74	43,436,021.50
35410	Бичиг хэргийн материал	1,750,113.74	1,946,545.00
35420	Аж ахуйн материал	00.00	8,298,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,049,694.00	4,925,349.00
35440	Түлш, шатах тослох материал	59,600.00	1,319,985.00
35470	Бусад хангамжийн материал	8,757,185.00	26,946,142.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,818,046.37</u>	<u>81,337,102.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,818,046.37	81,337,102.42
392	Биет хөрөнгө	31,818,046.37	81,337,102.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,000,000.00	58,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,000,000.00	-58,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	166,585,039.31	198,913,569.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-154,579,203.22	-132,559,532.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,164,870.00	52,514,870.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,352,659.72	-37,531,804.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>63,516,314.86</u>	<u>141,626,166.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>843,305.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	843,305.50
414	Урьдчилж орсон орлого	00.00	843,305.50
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	843,305.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>63,516,314.86</u>	<u>140,782,861.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	63,516,314.86	140,782,861.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	148,156,954.32	148,156,954.32
51101	Өмч: - төрийн	148,156,954.32	148,156,954.32
512	Хуримтлагдсан үр дүн	-84,640,639.46	-7,374,093.30
51210	Өмнөх үеийн үр дүн	-84,640,639.46	-84,640,639.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	77,266,546.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>63,516,314.86</u>	<u>141,626,166.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	529,814,484.55	585,416,950.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,243,384.55	118,144,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,243,384.55	118,144,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,060,124.55	118,042,470.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,060,124.55	118,042,470.00
120009	Бусад орлого	183,260.00	102,080.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	499,571,100.00	467,272,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	392,249,900.00	397,105,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,249,900.00	397,105,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,321,200.00	70,166,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,121,200.00	44,966,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	540,069,522.70	508,150,403.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,069,522.70	508,150,403.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	535,543,154.28	505,830,796.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,241,557.49	326,929,252.44
210101	Үндсэн цалин	200,644,480.49	246,562,309.02
210102	Нэмэгдэл	94,603,544.00	53,432,915.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,336,100.00	5,599,498.71
210105	Гэрээт ажлын хөлс	20,657,433.00	21,334,529.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,790,800.09	43,941,260.75
210201	Тэтгэврийн даатгал	30,773,463.09	32,151,736.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,388,900.00	2,991,377.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,583,440.00	2,355,962.30
210204	Ажилгүйдлийн даатгал	640,454.00	585,816.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,404,543.00	5,856,367.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,236,086.00	33,677,209.00
210301	Гэрэл, цахилгаан	5,102,514.00	5,009,286.00
210302	Түлш, халаалт	3,094,858.00	3,288,687.00
210303	Цэвэр, бохир ус	1,922,410.00	4,587,040.00
210304	Байрны түрээс	21,116,304.00	20,792,196.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,024,065.26	15,777,959.19
210401	Бичиг хэрэг	10,651,361.76	6,932,974.74
210402	Тээвэр, шатахуун	1,185,700.00	1,304,215.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,109,657.00	649,724.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,056,100.00	1,732,250.00
210408	Бараа материал акталсны зардал	6,021,246.50	5,158,795.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,103,666.55	6,506,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	238,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,623,266.55	5,072,200.00
210604	Урсгал засвар	3,242,400.00	1,434,000.00
2107	Томилолт, зочны зардал	287,000.00	115,200.00
210702	Дотоод албан томилолт	287,000.00	115,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,038,795.85	21,511,650.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,100.00	4,558,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,480.00	59,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,929,205.85	16,773,370.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,821,183.04	57,372,063.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,938,315.00	44,911,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	563,500.00	165,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,319,368.04	12,295,343.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,526,368.42	2,319,607.81

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	384,600.00	230,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	384,600.00	230,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,958,883.42	873,684.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,958,883.42	873,684.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	182,885.00	1,215,923.23
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	00.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,255,038.15	77,266,546.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,255,038.15	77,266,546.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	801,725,081.27	912,282,445.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,153,981.27	445,010,045.90
120	Нийтлэг татварын бус орлого	302,153,981.27	445,010,045.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	302,153,981.27	445,010,045.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	302,153,981.27	433,642,102.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	11,367,943.00
120009	Бусад орлого	00.00	00.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	499,571,100.00	467,272,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	392,249,900.00	397,105,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,249,900.00	397,105,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,321,200.00	70,166,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	82,121,200.00	44,966,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	801,725,081.27	911,439,140.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	801,725,081.27	911,439,140.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	495,044,731.58	464,952,792.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,058,297.49	326,827,172.44
210101	Үндсэн цалин	244,005,297.86	246,460,276.02
210102	Нэмэгдэл	49,595,558.67	53,432,915.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,312,440.96	5,599,498.71
210105	Гэрээт ажлын хөлс	21,145,000.00	21,334,482.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,790,800.09	43,941,260.75
210201	Тэтгэврийн даатгал	31,601,235.98	32,151,736.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,066,068.92	2,991,377.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,432,515.16	2,355,962.30
210204	Ажилгүйдлийн даатгал	608,353.76	585,816.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,082,626.27	5,856,367.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,236,086.00	33,677,209.00
210301	Гэрэл, цахилгаан	5,102,514.00	5,009,286.00
210302	Түлш, халаалт	3,094,858.00	3,288,687.00
210303	Цэвэр, бохир ус	1,922,410.00	4,587,040.00
210304	Байрны түрээс	21,116,304.00	20,792,196.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,556,943.00	9,069,950.00
210401	Бичиг хэрэг	5,145,886.00	4,752,576.00
210402	Тээвэр, шатахуун	1,245,300.00	2,564,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,109,657.00	649,724.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,056,100.00	1,103,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,254,100.00	1,429,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	797,000.00	45,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,066,800.00	143,000.00
210604	Урсгал засвар	4,390,300.00	1,241,000.00
2107	Томилолт, зочны зардал	287,000.00	115,200.00
210702	Дотоод албан томилолт	287,000.00	115,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,590.00	4,816,280.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,100.00	4,636,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,480.00	59,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,751,915.00	45,076,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,938,315.00	44,911,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	813,600.00	165,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	306,680,349.69	446,486,348.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	384,600.00	230,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	384,600.00	230,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	306,112,864.69	433,672,481.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,958,883.42	873,684.58
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	302,153,981.27	432,798,797.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	182,885.00	12,583,866.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,367,943.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	182,885.00	1,215,923.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	843,305.50
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	843,305.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	843,305.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-88,750,982.31	59,405,972.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	14,365,381.00	14,365,381.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,156,954.32	-74,385,601.31	73,771,353.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-10,255,038.15	-10,255,038.15
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-84,640,639.46	63,516,314.86
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-84,640,639.46	63,516,314.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,156,954.32	-84,640,639.46	63,516,314.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	77,266,546.16	77,266,546.16
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-7,374,093.30	140,782,861.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Биелэлт хувиар
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,105,900.00	396,232,215.42	873,684.58	99.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,105,900.00	396,232,215.42	873,684.58	99.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,875,500.00	396,002,215.42	873,284.58	99.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,739,100.00	305,492,690.43	246,409.57	99.92
210101	Үндсэн цалин	258,136,300.00	246,460,276.02	11,676,023.98	95.48
210102	Нэмэгдэл	41,266,800.00	53,432,915.70	-12,166,115.70	129.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	5,599,498.71	736,501.29	88.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,381,700.00	41,236,885.99	144,814.01	99.65
210201	Тэтгэврийн даатгал	30,250,500.00	29,447,361.84	803,138.16	97.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,782,800.00	2,991,377.87	-208,577.87	107.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,226,200.00	2,355,962.30	-129,762.30	105.83
210204	Ажилгүйдлийн даатгал	556,600.00	585,816.72	-29,216.72	105.25
210205	Эрүүл мэндийн даатгал	5,565,600.00	5,856,367.26	-290,767.26	105.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,094,100.00	33,677,209.00	416,891.00	98.78
210301	Гэрэл, цахилгаан	4,406,000.00	5,009,286.00	-603,286.00	113.69
210302	Түлш, халаалт	4,216,600.00	3,288,687.00	927,913.00	77.99
210303	Цэвэр, бохир ус	4,679,300.00	4,587,040.00	92,260.00	98.03
210304	Байрны түрээс	20,792,200.00	20,792,196.00	4.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,070,400.00	9,069,950.00	450.00	100.00
210401	Бичиг хэрэг	4,751,400.00	4,752,576.00	-1,176.00	100.02
210402	Тээвэр, шатахуун	2,565,500.00	2,564,600.00	900.00	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	589,000.00	649,724.00	-60,724.00	110.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,500.00	00.00	42,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,122,000.00	1,103,050.00	18,950.00	98.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,435,000.00	1,429,000.00	6,000.00	99.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000.00	45,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,000.00	143,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,247,000.00	1,241,000.00	6,000.00	99.52
2107	Томилолт, зочны зардал	115,200.00	115,200.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	115,200.00	115,200.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,875,000.00	4,816,280.00	58,720.00	98.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,673,500.00	4,636,800.00	36,700.00	99.21
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,500.00	59,480.00	20.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00	22,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,000.00	165,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	165,000.00	165,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	230,400.00	230,000.00	400.00	99.83

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	230,400.00	230,000.00	400.00	99.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	230,400.00	230,000.00	400.00	99.83
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	397,105,900.00	397,105,900.00	0.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	397,105,900.00	397,105,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	397,105,900.00	397,105,900.00	0.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	843,305.50	-843,305.50	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	25.00	1.00	96.15
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	17.00	1.00	94.44
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	25.00	1.00	96.15
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19.00	18.00	1.00	94.74
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	07.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлвөлгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70.166.500.00	68,950,576.77	1.215.923.23	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70.166.500.00	68,950,576.77	1.215.923.23	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70.166.500.00	68,950,576.77	1.215.923.23	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22.300.000.00	21,334,482.01	965.517.99	95.7
210105	Гэрээт ажлын хөлс	22.3000.000.00	21,334,482.01	965.517.99	95.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.900.000.00	2,704,374.76	195.625.24	93.3
210201	Тэтгэврийн даатгал	2.900.000.00	2,704,374.76	195.625.24	93.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44.966.500.00	44,911,720.00	54.780.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44.966.500.00	44,911,720.00	54.780.00	99.9
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70.166.500.00	70,166,500.00		100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70.166.500.00	70,166,500.00		100.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25.200.000.00	25,200,000.00		100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44.966.500.00	44,966,500.00		100.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгө, урсгал зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн аудитор Б.Байгал гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, ахлах аудитор Л.Баасандорж нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, Б.Эрдэнэ, газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Орхон аймгийн 2 сум, 105000 мянган иргэнд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн удирдамж чиглэлийн дагуу шуурхай хүргэх эрхэм зорилготойгоор дараах үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Иргэний бүртгэлийн үйл ажиллагаа;
- ✓ Эд хөрөнгө өмчлөх эрх;
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын хувьд үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлэн бараа материалд бүртгэсэн, урсгал зардалд бичих болон үндсэн хөрөнгөнд бүртгэж элэгдүүлэх авто машины сэлбэг хэрэгслийг бараа материалд олон жил бүртгэсэн, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтрийг бүрэн хөтлөөгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг дагаж мөрдөх ажил хангалтгүй байна.

Тайлант онд Жаргалант суманд Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний сүлжээ тавигдсан нь улсын бүртгэлийн үйлчилгээг онлайн горимд бүртгэх боломжтой болсон,

төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэх ажлын хүрээнд үйлчилгээний төлбөрийг киоск машинаар төлүүлдэг болсон зэрэг байгууллагын ерөнхий үйл ажиллагааны хяналт үр нөлөөтэй байгааг илтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй УБЕГ-ийн Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Уг ажлын хүрээнд орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 3/4446 тоот албан бичгээр 6 зөвлөмж хүргүүлсэн. Мөн 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 3-2/9014 тоот албан тоотоор 4 зөвлөмж өгч, санхүүгийн ажилтнуудад цахим болон танхим хосолсон сургалтуудыг зохион байгуулсан байна.

УБЕГ-ийн Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас ирүүлсэн зөвлөмжийн талаар тус хэлтсийн ажилтнууд тодорхойлсон ажил зохион байгуулаагүй, ажилтнууддаа өгсөн үүргийн хэрэгжилтийг хянаагүй байгаа зэрэг нь санхүүгийн дотоод хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 361,336.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,226.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,058.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг тогтоохдоо тайлант оны батлагдсан санхүүжилтийн дүнг суурь болгож авсан. Гүйцэтгэлийн үе шатанд суурь өөрчлөөгүй, гүйцэтгэлийн санхүүжилтийн дүн 465,182.8 мянган төгрөг болж өссөн тул өмнөх тогтоосон түвшин 2 хувиар тооцоход 2,076.9 мянган төгрөгөөр материаллаг байдал нэмэгдүүлэх зөрүү үүссэн. Тиймээс ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэж материаллаг байдал 7,226.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал 5,058.7 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,109.9 мянган төгрөгөөр буюу 123.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	-	843.3	843.3	100.0
Авлага	-	-	-	-
Урьдчилгаа	-	-	-	-
Бараа материал	31,698.3	59,445.8	27,747.5	87.5
Үндсэн хөрөнгө	31,818.0	81,337.1	49,519.1	155.6

Нийт хөрөнгө	63,516.3	141,626.2	78,109.9	123.0
Өр төлбөр	-	843.3	843.3	100.0
Засгийн газрын оролцоо	63,516.3	140,782.9	77,266.6	121.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч	63,516.3	141,626.2	78,109.9	123.0

Тус байгууллага нь Төрийн сан банканд үндсэн болон нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх орлогын 3 данс, Төрийн банканд үйлчилгээний орлогын 3 данстай болно.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210012012 тоот дансаар 412,075.8 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Үүний 397,105.9 мянган төгрөг нь санхүүжилтийн орлого, 2,980.2 мянган төгрөг нь ХЧТАТ-ийн орлого, 11,989.7 мянган төгрөг нь нэр данс зөрүүтэй ажил гүйлгээнээс үүссэн орлого байна. Эдгээр мөнгөн орлогоос 11,989.7 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээ залруулагдаж, 399,212.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, үлдэгдэл 873.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 100210012420 тоот дансаар 71,079.4 мянган төгрөгийн орлого орж зарцуулагдсан байна. Мөнгөн орлого нь орон нутгийн төсвөөс цалинждаг 4 гэрээт ажилтны цалин 25,200.0 мянган төгрөг, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардал 44,966.5 мянган төгрөг, нэр данс зөрүү 912.9 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 24,038.9 мянган төгрөгийг гэрээт ажилтны цалин, НДШ-д зарцуулж, 44,911.7 мянган төгрөгийг Ерөнхийлөгчийн сонгуульд ажилласан ажилтны ажлын хөлс, бараа үйлчилгээний зардалд, 912.9 мянган төгрөг нэр данс зөрүүг залруулсан, 1,215.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Төрийн банканд байгаа үйлчилгээний орлогын данснууд оны эхэнд 6 данстай байсан. Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү аж ахуй хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжинд 2021 оны 10 дугаар сарын 27-нд 1330 тоот албан бичгээр тэг үлдэгдэлтэй 130000070576, 130000070584, 130000070592 тоот данснуудыг хаахаар хүсэлт явуулсны дагуу Төрийн банк хаасан байна. Хагас жилээс хойш ашиглаж байгаа 413000070615 дансанд 712.0 мянган төгрөг, 413000070628 дансанд 108.0 мянган төгрөг, 4130400030007 дансанд 23.3 мянган төгрөг тус тус үлдэгдэлтэй байна. Энэ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 17 цагаас хойш орсон үйлчилгээний орлого дансанд үлдэгдэл үүсгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 87.5%-аар буюу 27,747.5 мянган төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас тусгай зориулалтын материалд 19,980.1 мянган төгрөгийн хэвлэмэл маягт, хавтас, үнэт цаас нийлүүлсэн. Нийлүүлсэн материалаас 2,344.0 мянган төгрөгийн үнэтэй 2040 ширхэг цэнхэр хавтас, 1,930.0 мянган төгрөгийн үнэтэй 20000 ширхэг хувийн хэргийн дугтуй, 2,659.2 мянган төгрөгийн 3324 ширхэг төрсний гэрчилгээний хавтас зэрэг бараануудыг өмнөх 3 жилийн зарцуулалтын дундажтай харьцуулахад хайрцган цэнхэр хавтсыг 9 жил, хувийн хэргийн дугтуйг 7 жил, төрсний гэрчилгээний хавтас 1 жил хэрэглэх нөөц үүсгэсэнтэй холбоотой үлдэгдэл 7.5 хувиар өссөн байна.
- Бичиг хэргийн материал зарцуулалтаас харахад өмнөх оноос буурахаар байсан боловч 196.4 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн нь бичгийн цаас 112 ширхгийг 1,400.0 мянган төгрөгөөр бэлтгэж 1 жилийн нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.
- Аж ахуйн материал өмнөх онд үлдэгдэлгүй байсан энэ онд 8,298.0 мянган төгрөгөөр үлдэгдэл өссөн. Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койка"-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд бэлтгэж нийлүүлсэн 4 төрлийн 7,990.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалд бүртгэсэнтэй холбоотой өссөн байна.
- Түлш шатахуун үлдэгдэл 1,319.9 мянган төгрөг өмнөх оноос өссөн байна. Энэ нь үлдэгдэл санхүүжилтээр 1,319.9 мянган төгрөгийн 1 жилийн хэрэгцээний шатахууны нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.
- Бусад хангамжийн материал өмнөх оноос 18,188.9 мянган төгрөг буюу 306.6 хувиар өссөн байна. Энэ өсөлтөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койка"-ийн санхүүжилтээр Улсын

бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд бэлтгэсэн хамгаалах маск 7100 ширхэг 12,780.0 мянган төгрөг, гар ариутгагч бодис 323 ширхэг 6,460.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлсөн байна.

- Бараа материалын дансны үлдэгдлийн өсөлт нь үндсэн хөрөнгө бараа материалд бүртгэсэн, төсвийн хэмнэлтийг зарцуулж нөөц үүсгэсэн, Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийлүүлсэн бараа материал нь тоо болон нэгжийн өртгийн хувьд өндөр олон жилийн хэрэгцээг хангах тооцоо судалгаагүй бараа нийлүүлсэнтэй холбоотой өмнөх оноос 87.7 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 155.6%-аар буюу 49,519.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд дараах хөрөнгүүдийн хөдөлгөөн, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

- Машин тоног төхөөрөмжийн өсөлт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-1/1694 тоот албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койка"-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд бэлтгэж нийлүүлсэн 7 төрлийн 43,930.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна. Уг хөрөнгөнд принтер, сканер, дижитал камер, хурууны хээ уншигч гэсэн хөрөнгө байна. Мөн Орхон аймгийн ЗДТГ-аас орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4 төрлийн 17,543.3 мянган төгрөгийн хувилагч, принтер, сканер, нэмэгдсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 он 12 дугаар сарын 30-ны өдрийн 720 дугаар тогтоолын дагуу 5 төрлийн 23 ширхэг 29,135.9 мянган төгрөгийн компьютер, хурууны хээ уншигч, бар код уншигч зэрэг тоног төхөөрөмжийг акталж үндсэн хөрөнгөнөөс хасагдсан байгаа нь бас нөлөөлсөн байна.
- Тавилга эд хогшил 350.0 мянган төгрөгөөс өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 314 дугаар тогтоолын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас шилжүүлсэн 350.0 мянган төгрөгийн 3 төрлийн 10 ширхэг ширээ, шургуулаг, сандал шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны өөрчлөлт нь, үйлчилгээний орлогын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 17 цагаас хойших орлогыг харилцах дансанд үлдэгдлээр бүртгэж урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байгаатай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 77,266.6 мянган төгрөгөөр буюу 121.6%-аар өсөж 140,782.9 мянган төгрөг болжээ. Үүнд тайлант үеийн үр дүн 77,266.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Төрийн өмчид өөрчлөлт ороогүй байна.

Орлогын нэр төрөл	Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020 он	2021 он	Өөрчлөлт	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,249.9	397,105.9	4,856.0	1.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,060.1	118,042.5	87,982.4	392.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,121.2	44,966.5	(37,154.7)	(54.7)
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	25,200.0	25,200.0	0	0
Бусад орлого	183.3	102.0	(81.3)	(55.6)
Нийт орлого	529,814.5	585,416.9	55,602.4	10.5

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 55,602.4 мянган төгрөгөөр буюу 10.5%-аар өссөн байна. Үүнд, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1.2 хувь буюу 4,856.0 мянган төгрөгөөр өссөн, Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал хөрөнгийн орлого 292.7 хувь буюу 87,982.4 мянган төгрөгөөр өсөж, Улсын их хурлын сонгуулийн зардлаас Ерөнхийлөгчийн сонгуулийн зардал 54.7 хувь буюу 37,154.7 мянган төгрөгөөр бага зарцуулагдсан зэрэг нөлөөлсөн байна. Орлогыг нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1.2%-аар буюу 4,856.0 мянган төгрөгөөр өссөн нь анх батлагдсан төсөвт өөрчлөлт орж цалин хөлс НДШ-ийн зардал, төлбөр хураамжийн зардлууд дээр нийт 35,372.0 мянган төгрөг нэмж хуваарь хийсэнтэй холбоотой байна.

- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөн нь энэ онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койка"-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд 19 төрлийн 76,748.9 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материал нийлүүлсэнтэй холбоотой байна.
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө нь өмнөх онд орон нутгийн сонгуулийн зардал өндөр дүнтэй тайлант онд Ерөнхийлөгчийн сонгуулийн зардал бага дүнтэй зарцуулагдахаар төлөвлөсөнтэй холбоотой уг орлого 37,154.7 мянган төгрөгөөр буюу 54.7%-аар буурсан байна.

Үзүүлэлт	Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	540,069.5	508150.4	(31,919.1)	-5.9
УРСГАЛ ЗАРДАЛ	540,069.5	508150.4	(31,919.1)	-5.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	535,543.1	505,830.8	(29,712.3)	-5.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,241.5	326,929.2	5,687.7	1.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,790.8	43,941.3	150.5	0,3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,236.1	33,677.2	2,441.1	7,8
Хангамж, бараа материалын зардал	20,024.1	15,777.9	(4,246.2)	-21.2
Эд хогшил, урсгал засварын зардал	5,103.7	6,506.2	(1,690.2)	27,5
Томилолт, зочны зардал	287.0	115.2	(702.0)	-59,9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,038.8	21,511.6	1,472.8	7,3
Бараа үйлчилгээний бусад зардал	93,821.1	57,372.1	(36,449.0)	-38,8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,526.4	2,319.6	(2,206.8)	-48.7
Бусад урсгал шилжүүлэг	384.6	230.0	(154.6)	-40.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,958.9	873.7	(3,085.2)	-77.9
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	182.9	1,215.9	1,033.0	564.8

Нийт зардал өмнөх оноос 5.9%-аар буюу 31,919.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын бууралтын нөлөөлөл нь:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд хангамжийн бараа материалын зардлын бууралт 21.2%-аар буюу 4,246.2 мянган төгрөгөөр, Томилолт зочны зардал 59.9%-аар буюу 702.0 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардал 38.8%-аар буюу 36,449.0 мянган төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын бууралт Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг өмнөх оноос 77.9% буюу 3,085.2 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 40.2%-аар буюу 154.6 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 77,266.5 мянган төгрөгөөр буюу 121.6%-аар өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төсвийн төсөл боловсруулж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлдэг. Улсын бүртгэлийн ерөнхий газраас төсвийн төсөл батлагдан системийн хэмжээнд дотоод сүлжээгээр, цаасаар илгээгдэж ирдэг.

Батлагдсан төсвийн зарлага болох 467,272.4 мянган төгрөгийн 397,105.9 мянган төгрөг буюу 85.0%-ийг улсын төсвөөр, 70,166.5 мянган төгрөг буюу 15.0%-ийг орон нутгийн төсвийн санхүүжилт, УБЕГ-аас шилжүүлсэн сонгуулийн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхээр баталжээ.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 467,272.4 мянган төгрөг болж тодотгосон төсвийн дүн өмнөх оны төлөвлөгөөнөөс

8.2%-аар буюу 35,372.0 мянган төгрөгөөр өссөн бол 2020 оны анхны батлагдсан төсөв нь 18.6%-аар буюу 98,379.1 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь	2021 оны тодотгол зөрүү	Хувь
		2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,279,500.00	431,900,400.00	467,272,400.00	(98,379,100.00)	81.45%	35,372,000.00	108.19%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	530,279,500.00	431,612,400.00	467,042,000.00	(98,667,100.00)	81.39%	35,429,600.00	108.21%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,783,120.00	300,276,200.00	328,039,100.00	(68,506,920.00)	81.42%	27,762,900.00	109.25%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,733,810.00	41,167,700.00	44,281,700.00	(7,566,110.00)	84.47%	3,114,000.00	107.56%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,499,620.00	31,512,000.00	34,094,100.00	(2,987,620.00)	91.34%	2,582,100.00	108.19%
2104	Хангамж, бараа материалын зардал	17,779,760.00	10,244,000.00	9,070,400.00	(7,535,760.00)	57.62%	(1,173,600.00)	88.54%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,009,800.00	1,632,000.00	1,435,000.00	(7,377,800.00)	18.11%	(197,000.00)	87.93%
2107	Томилолт, зочны зардал	2,670,000.00	192,000.00	115,200.00	(2,478,000.00)	7.19%	(76,800.00)	60.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580,890.00	902,000.00	4,875,000.00	(678,890.00)	57.06%	3,973,000.00	540.47%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,222,500.00	45,686,500.00	45,131,500.00	(1,536,000.00)	96.75%	(555,000.00)	98.79%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,040,000.00	288,000.00	230,400.00	(4,752,000.00)	5.71%	(57,600.00)	80.00%
2132	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,040,000.00	288,000.00	230,400.00	(4,752,000.00)	5.71%	(57,600.00)	80.00%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	460,113,000.00	431,900,400.00	467,272,400.00	(28,212,600.00)	93.87%	35,372,000.00	108.19%
1E+05	Улсын төсвөөс	460,113,000.00	361,733,900.00	397,105,900.00	(98,379,100.00)	78.62%	35,372,000.00	109.78%
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,166,500.00	70,166,500.00	70,166,500.00	-	100.00%	-	100.00%

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, Ажил олгогчоос төлөх НДШ: 2021 онд уг зардлыг санхүүжүүлэх төсөв өмнөх оны батлагдсан төлөвлөгөөнөөс 16.7%-аар буюу 30,876.9 мянган төгрөгөөр өссөн энэ онд нэмж тодотгосонтой холбоотой нэмэгдсэн байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 8.2%-аар буюу 2,582.1 мянган төгрөгөөр өссөн цэвэр бохир усны зардал дээр 12 дугаар сард 1 удаа төсвийн зохицуулалт хийгдсэн.
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос 42.4%-аар буюу 7,535.8 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 11.5%-аар буюу 1,173.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Уг бүлэг зардалд нэмэлт зохицуулалт хийгдээгүй тайлант онд хэмнэлтэй зарцуулсан байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнөх оноос 81.9%-аар буюу 7,377.8 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 12.1%-аар буюу 197.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна энэ онд засвар үйлчилгээ хийгээгүйтэй холбоотой байна.
- Томилолт, зочны зардал: Өмнөх оноос 92.8%-аар буюу 2,478.0 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 40.0%-аар буюу 76.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна энэ онд цар тахлын нөхцөл байдлаас болж цахимаар сургалт, хурал зөвлөгөөн хийгдсэнтэй холбоотой байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос 42.9%-аар буюу 3,973.0 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 540.4%-аар буюу 76.8 мянган төгрөгөөр өссөн нь хорооллын 1 цонхны сүлжээний сувагчлалын засварын зардал гарсантай холбоотой нэмж тодотгосонтой холбоотой байна.
- Бараа үйлчилгээний бусад зардал: Өмнөх оноос 3.25%-аар буюу 1,536.0 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 1.2%-аар буюу 555.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байгаа нь зарцуулалт буурсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 467,272.4 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 397,105.9 мянган

төгрөгийг, орон нутгийн төсвийн орлогоос 70,166.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 465,182.8 мянган төгрөг буюу 99.5% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,272.0	465,182.8	2,089.6	99.55%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,042.0	464,952.8	2,089.2	99.55%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,039.1	326,827.2	1,211.9	99.63%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,281.7	43,941.3	340.4	99.23%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,094.1	33,677.2	416.9	98.78%
2104	Хангамж, бараа материалын зардал	9,070.4	9,069.9	0.4	100.00%
2105	Нормативт зардал	-	-	-	0.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,435.0	1,429.0	6.0	99.58%
2107	Томилолт, зочны зардал	115.2	115.2	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,875.0	4,816.3	58.7	98.80%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,131.5	45,076.7	54.8	99.88%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	230.4	230.0	0.4	99.83%
2132	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	230.4	230.0	0.4	99.83%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	467,272.4	467,272.4	-	100.00%
131001	Улсын төсвөөс	397,105.9	397,105.9	-	100.00%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,166.5	70,166.5	-	100.00%

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 1,211.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 340.4 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 416.9 мянган төгрөгийн, эд хогшил урсгал засварын зардлаас 6.0 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 58.7 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 54.8 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 0.4%-аар хэмнэгджээ. Харин улсын төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 467,272.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 396,232.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 873.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвийн орлогоос 68,950.6 мянган төгрөгийг зарцуулж 1,215.9 мянган төгрөгийг ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Улсын бүртгэлийн ерөнхий газраас орон нутгийн хэлтсүүдэд үйлчилгээний орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрээр биш нийт дүнгээр өгсөн байна. Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн энэ оны төлбөрт үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 320,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж ирүүлсэн байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
1	Улсын бүртгэлийн төлбөрт үйлчилгээ	320,000.0	432,798.8	112,798.8	135.2

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоолоор “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ”-г хавсралтаар шинэчлэн тогтоосон ба тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой орлогын төлөвлөгөө 135.2 хувиар давж биелсэн байна. Энэ оны эхний хагас жилд Төрийн банканд орлогын 6 данстай байсныг цөөлж 3 данстай болгосон байна. Орсон орлогыг орон нутгийн төрийн сангийн орлогын дансаар дамжуулан сангийн яамны орлогын дансанд төвлөрүүлж байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвийн орлогоос 4 түр гэрээт ажилтнуудын цалин 25,200.0 мянган төгрөг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас Ерөнхийлөгчийн сонгуулийн зардалд зарцуулахаар 44,966.5 мянган төгрөг, нийт 70,166.5 мянган төгрөг төвлөрсөн. Уг санхүүжилтээс цалингийн зардалд 21,334.5 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 2,704.4 мянган төгрөг, сонгуулийн материалын болон урамшууллын зардалд 44,911.7 мянган төгрөг тус тус зарцуулж, 1,215.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын хийх явцад аудитын баг холбогдох нотлох баримтыг саадгүй авч ашигласан бөгөөд тайлант оны санхүүгийн ажил гүйлгээ санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн хүрээнд аудит хийгдсэн.

3.8 Аудитын гол асуудал

Төслийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал

Тайлант онд Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "Койко"-ийн санхүүжилтээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд 76,749.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслийн бараа материалыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийлүүлсэн.

Хөрөнгө, бараа материалыг тулган шалгахад зарим бараа бүтээгдэхүүн нэгжийн өртөг зах зээлийн үнээс 2-5 дахин өндөр үнэтэй, нийлүүлсэн тоо хэмжээг сүүлийн 3 жилийн зарцуулалтын дундаж тоотой харьцуулахад хамгаалах маскийг 11 жил, гар ариутгагч бодисыг 24 жил хэрэглэх нөөц үүсгэсэн байна. Тухайлбал хамгаалах маск 9000 ширхгийг нэг бүрийг нь 1800 төгрөгөөр бэлтгэж 16,200.0 мянган төгрөгөөр, гар ариутгагч бодис 364 ширхгийг нэг бүрийг нь 20000 төгрөгөөр бэлтгэж 7,200.0 мянган төгрөгийн өртөгтэй нийлүүлсэн байгаа нь уг бараануудын нэгжийн өртөг зах зээлийн үнээс 2-5 дахин өндөр үнэтэй байна. Энэ 2 барааг сүүлийн 1 жилийн зарцуулалтаар харьцуулахад 4-8 жилийн нөөц агуулахад хадгалагдаж байна. Гэтэл гар ариутгагч шингэн, хамгаалах маск зэрэг нь хадгалалтын тусгай горимд, тодорхой хугацаанд ашиглах боломжтой байдаг. Энэ нь хэрэгцээ шаардлагыг тооцоогүй Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1.-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заасан заалтыг зөрчсөн тус хэлтсийн бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд худалдан авсан бараа материал, үндсэн хөрөнгийн

нэгжийн өртөг тоо хэмжээг, хэрэгцээ шаардлагатай уялдсан эсэх болон уг төслийн санхүүжилтийн үр дүн үр өгөөжийг гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай байна гэсэн саналыг ТАГ-т хүргүүлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих төсөв гүйцэтгэлийн 49, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 39, бусад 61, нийт 149 төрлийн мэдээлэл байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төлөвлөлт ба зохицуулалтын талаарх асуудал

Тайлант хугацаанд Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн батлагдсан төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт оруулсан гэсэн тайлбар ирсэн боловч холбогдох нотлох баримт байхгүй байна. Төсвийн тодотгол хийхдээ Улсын бүртгэлийн Ерөнхий газар цахимаар саналыг авах, төсвийн хуваарьт хасалт хийхэд санал харгалзахгүй хасаж зохицуулдаг тул хасагдсан болон нэмэгдсэн төсвийн хуваарь тус байгууллагат байхгүй байна. Улсын бүртгэлтийн ерөнхий газар Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.2-т заасан төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар хийсэн баримт бичгийг бүрдүүлж төсвийн зохицуулалт хийж байх шаардлагатайг анхаарах нь зүйтэй байна.

Энэ асуудал нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт “Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх”, Сангийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 134 дүгээр тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1, 3.2 дахь заалтад бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж дүгнэлээ.

Бараа материалын нөөц үүсгэсэн талаар

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн хайрцган цэнхэр хавтас 2040 ширхэг нэгжийн дундаж өртөг 1149 төгрөг нийт өртөг 2,344.0 мянган төгрөг, хувийн хэргийн дугтуй 20000 ширхэг нэгжийн дундаж өртөг 96.5 төгрөг нийт өртөг 1,930.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бараа тусгай зориулалтын материалын үлдэгдэлд бүртгэлтэй байна. Эдгээр бараануудын хэрэгцээг тооцоход хайрцган цэнхэр хавтсыг 2021 онд 317 ширхэг, 2020 онд 120 ширхгийг тус тус зарцуулсан, одоо байгаа үлдэгдлийг сүүлийн жилийн зарцуулалтаар тооцоход 6,5 жил хэрэглэхээр нөөц үүсгэсэн байна. Хувийн хэргийн дугтуйг 2021 онд 4480 ширхэг, 2020 онд 1520 ширхэг тус тус зарцуулсан, одоо байгаа нөөцийг 4,5 жил хэрэглэх нөөц байна.

Дээрх 2 төрлийн тусгай зориулалтын бараа материалын тооцооллоос дүгнэж үзэхэд хэрэгцээ шаардлагыг зөв тооцож орон нутгийн байгууллагуудад байгаа үлдэгдэл нөөцөө ихэсгэхгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дээрх нөхцөл байдал болон энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 зөвлөмжийн өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1		-		0
Нийт дүн	1		1		-		0

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 21 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, картжуулалт, үндсэн хөрөнгийн паспорт хөтлөлт, хөрөнгөд тавигдах дотоод хяналтын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,959.1 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчил илэрснээс, 12,971.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5,987.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавигдаагүй болно.

4.3 Албан шаардлага

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн шинжтэй 11 нэр төрлийн тоног төхөөрөмж, эд хогшил нийт 12,971.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын ангилалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1.-т "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" 20.1.2.-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах" гэсэн заалтуудыг зөрчиж НБББББ-ийн 3.5.2-т "Хөрөнгө оруулалтын тусгай бодлого" хэсгийн Хөрөнгө оруулалтын бүртгэл хэсэгт "Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсвөөр хийгдсэн хөрөнгө нь холбогдох стандартын (УСНББОУС 17) дагуу санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө, эсвэл тайлант оны зардлаар тусгана", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалд заасан заалтуудыг тус тус нийцэхгүй, толилуулга, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд хэмнэгдсэн 2,719.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтээс дараа онд зарцуулах бичгийн цаас, шатахууныг худалдан авч нөөц үүсгэсэн байна. Цаасны нөөц нь өмнөх 3 жилийн зарцуулсан дүнтэй харьцуулахад 1 бүтэн жилийн хэрэглээтэй дүйцэхээр, Шатахууны нөөцийг тоо хэмжээгээр бус өртгөөр тооцож үзэхэд 1 жилийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний нөөц тус тус үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45.2-т "*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ*" заасан заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын үлдэгдлийг зохистой түвшинд барих, 2022 оны батлагдсан зардлаас бичгийн цаас болон шатахууны 2,719.9 мянган төгрөгийг хасаж буцаан төвлөрүүлэх,

2. Шатахууны бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд зарцуулсан 1,244.6 мянган төгрөгийн шатах тослох материалын тоо хэмжээг литрээр илэрхийлэхийг ширхгээр илэрхийлсэн, нэгжийн өртгийг худалдан авсан бүтээгдэхүүний нэгжийн өртгөөр бус талоны мөнгөн дүн, картын үлдэгдлийн дүнгээр тус тус бүртгэсэн байна. Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс шатахууны тухай жилд худалдан авсан нэгжийн өртөг, дундаж өртөг, тайлант оны зарцуулсан хэмжээг тодорхойлоход боломжгүй, тайлан баримтыг үдэж цэгцэлж архивын нэгж болгох ажлыг хангалтгүй хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*" 5.1.5. "*хэмжигдэхүйц байх*" 13.1. "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*" Гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын бүртгэлд шатахууныг литрээр, нэгжийн өртгийг тухайн өдрийн нэгжийн өртгөөр бүртгэлд тусгах, шатахууны тайлан тооцоог үнэн зөв гаргаж архивын нэгж болгон хагас бүтэн жилээр үдэж цэгцэлж байх.

3. Хөрөнгийн ангилалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдэлд бүртгэлтэй байгаа 592.0 мянган төгрөгийн вакум хаалгыг урсгал зардалд бичээгүй, 1431.0 мянган төгрөгийн авто машины дугуй, аккумуляторыг үндсэн хөрөнгөнд бүртгээгүй эдэлгээний нормын дагуу элэгдэл тооцоогүй, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт зарим сэлбэг хэрэгслийг тэмдэглээгүй байна. Энэ нь Улсын бүртгэлийн хэлтсийн мөрдөж байгаа НББ-ийн бодлогын баримт бичгийн "Үндсэн хөрөнгийн ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд" хэсэгт "*Үндсэн хөрөнгөнд урсгал засвар хийхэд гарсан зардлын дүнгээр үндсэн хөрөнгийн урсгал засварын зардалд, Засвар сайжруулалтын зардал нь их засварын шалгуурт нийцэж байвал гарсан засварын зардлыг капиталжуулна*" Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2-т "*Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг*

норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллахыг авто тээврийн байгууллага, аж ахуйн нэгж, авто тээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөсүгэй” заасан заалтыг зөрчсөн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн засвар, сэлбэгийн зардлыг НББ-ийн бодлогын баримт бичигт заасны дагуу бүртгэх, тээврийн авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт тухай бүрд нь тэмдэглэгээ хийж баталгаажуулах, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	4	18,959.1	-	-	-	-	1	12,971.5	3	5,987.6

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ийн

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:



Б.БАЙГАЛ

Огноо: 11/18.

М.БЯМБАДОРЖ

Огноо:

Л.БААСАНДОРЖ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:

